



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД УХНААГИЙН ХҮРЭЛСҮХИЙН ИВЭЭЛ ДОР

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ” УЛСЫН ХОЁРДУГААР ЗӨВЛӨГӨӨН - 2018



Хүүхэд, залуучуудын хөгжлийн өнөөгийн байдал

Боловсролын хүрээлэн, Хүний
хөгжлийн судалгааны сектор




Агуулгын хүрээ

- Бүх шатны боловсролын бодлого, түүний хэрэгжүүлэхэд монгол хүүхдийн хөгжлийн онцлогийг тусгаж байна уу?
- Монгол хүүхдийн танин мэдэхүйн хөгжил ямар онцлогтой вэ?
- Монгол хүүхдийн нийгэмшлийн онцлог юу вэ?
- Монгол хүүхдийн бие бялдрын хөгжил ямар онцлогтой вэ?
- Монгол хүүхдийн хөгжилд юу нөлөөлж байна вэ?
- Монгол хүүхдийн хөгжлийн орчин ямар байна вэ?




Хүүхдийн хөгжил гэж юу вэ?







Хүүхдийн хөгжилд анхаарал татаж буй байдал





Хүүхдийн хөгжлийн онцлог

Бие бялдар	Танин мэдэхүй	Нийгэмшил
10-12 насанд охид илүү өндөр, 14 наснаас эхлэн хөвгүүд өндөр	Мэдээллийг хүртэхдээ ерөнхийд нь хүртэх хандлагатай.	Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх нь эерэг
Охидын өндөр 14 наснаас, хөвгүүдийнх 16 наснаас удааширсан	Юмсыг гадаад байлаар нь харьцуулах чадвартай, дотоод мөн чанар, учир шалтгаанд нь харьцуулах нь сул	Нийцтэй, нөхөрсөг, бусадтай харилцах, хамтрах сонирхол сайтай
Охидын биеийн жин 11-14 насанд, хөвгүүдийн биеийн жин 13-15 насанд нэмэгдсэн.	Нарийн мэдээлэл агуулсан байнга хэрэглэдэггүй үг хэллэгтэй мэдээллийг утгачлан тогтоох нь сул	Өсвөр насанд бусдыг хүлээн зөвшөөрөх нь буурч, шүүмжлэлтэй хандлага бий болно
12 наснаас эхлэн суурь боловсролын түвшинд хүүхдүүдийн хурд саарсан 15-17 насанд хөвгүүдийн хурд нэмэгдсэн. Нийт насанд хөвгүүдийн хурд илүү.	Өдөр тутам байнга хэрэглэдэг, бодит юмсыг заасан үгийн нөөц давамгайлдаг. Тэмдэг нэр, салаа утгатай үгийн нөөц сул	Өсвөр насанд эцэг эхтэйгээ дотно харилцах нь суларсан.
Хөвгүүдийн хүчний чанар анги ахих тусам нэмэгдсэн, охидынх 12 наснаас эхлэн сайжраагүй.	Энгийн богино өгүүлбэрээр ярьдаг. “бөгөөд, гэвч, учраас, боловч, миний бодлоор” гэх мэт холбоос хэрэглэсэн нийлмэл өгүүлбэрийг нийт хүүхдүүд хэрэглэх нь маш сул	Өсвөр насанд айдас нэмэгдсэн.



Хөгжилд нөлөөлж байгаа хүчин зүйл



Бие бялдар

- Эцгийн боловсрол, ажил эрхлэлт,
- өрхийн орлого
- Спортоор хичээллэдэг эсэх
- Ам бүлийн тоо

Танин мэдэхүй

- Эцгийн боловсрол, ажил эрхлэлт
- Өрхийн орлого
- Харилцаа
- Олон нийтийн ажил
- байршил

Нийгэмшил

- Амьдардаг газар
- Спортоор хичээллэдэг байдал
- Унтдаг цаг
- Амьдралын нөхцөл



Шийдвэрлэх асуудал





Бодлогын түвшинд

1. Монгол хүүхдийн хөгжлийн судалгааг 3 жилийн давтамжтай 3-аас цөөнгүй удаа хийх шаардлагатайг анхаарч, эн тэргүүний ач холбогдол өгч дэмжих,
2. Монгол хүүхдийн хөгжлийн судалгааг хийх үндэсний хүний нөөцийг бэхжүүлэх, хөгжүүлэхэд тогтмол дэмжих,
3. Бүх шатны боловсролын байгууллагын мэргэжилтэн, аргазүйчид үйл ажиллагаандаа хүүхдийн хөгжлийн онцлогийг харгалзах чиглэлийг тодорхой болгох,
4. Аймаг, нийслэл, дүүрэг, сургуулийн түвшинд хүүхдийн хөгжлийг оношлох цахим хувилбарыг ашиглах техник хангамж болон хүний нөөцийг бэхжүүлэхэд бодлогоор дэмжих,



Үндэсний байгууллагуудын түвшинд

1. Орон нутаг, сургууль өөрийн онцлогийг тусгасан бодлогоо хэрэгжүүлэхэд нь хүүхдийн хөгжлийн онцлогт тулгуурлах талаар мэргэжил, аргазүйн дэмжлэг үзүүлэх,
2. Багш боловсролын хөтөлбөрт хүүхдийн хөгжил, насзүйн сэтгэл судлал, хөгжлийн оношлогооны аргазүй, хөгжлийн онцлогт суурилсан сургалтын аргазүйн агуулгыг бүтээлчээр тусгах, энэ чиглэлийн сургалтын чанарыг цаг алдалгүй сайжруулах,
3. Сургалтын хөтөлбөр, сурах бичгийн чанарт тухайн насны хүүхдийн хөгжлийн онцлогийн талаас нь судлан шинжилж, сайжруулах арга замыг тодорхойлох,
4. Сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулагчдыг сонгох, ажлын явцад мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэхдээ хүүхдийн хөгжлийн онцлогийн талаар мэдлэг, ойлголтыг дэмжих.
5. Хүүхэд бүр сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нөхцлийг бүрдүүлэх.



Сургуулийн түвшинд

1. Бие бялдрын тэсвэрийн чанар нь хүүхдийн танин мэдэхүй нийгэмшлийн хөгжилтэй холбоотой байгаа тул сургуулийн биеийн тамирын гадаад талбайг стандартын хэмжээнд байгуулах, энэ талбайг алдахгүй байхад удирдах байгууллагуудтай хамтран ажиллах.
2. Сургуулиас зохион байгуулдаг аливаа ажилд хүүхдийн оролцоог хангах нь хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдрын хөгжилд чухал байгаа тул хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцсэн олон төрөлт ажлыг тогтмол хэрэгжүүлэх.
3. Суурь боловсролын түвшинд хүүхдийн бие бялдрын хөгжлийн өсөлт эрчимтэй байдаг тул энэ шатны биеийн тамирын хичээлийн чанарыг сайжруулах, мэргэжлийн техник хэрэгслээр хангахад онцгой анхаарах.
4. Мөн суурь боловсролын түвшний хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөн тогтворгүй байгааг анхаарч энэ насны хүүхдүүдийн өөрсдийн сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгож харилцах, харилцааны үед бусдад анхааралтай хандах чадварыг дэмжин хөгжүүлэхэд багш нар, нийгмийн ажилтантай хамтран ажиллах.



Багшийн хувьд:

- Сэтгэхүйн бүтээлч чанар, анхаарлын тогтворжилт, юмсын харьцаа холбоог таньж, сэтгэхүйн харьцуулах үйлдлийг хөгжүүлэхэд сургалтыг чиглүүлэх.
 - **Бага боловсролын түвшинд** бодит үйлдийн сэтгэхүй, ажигч чанарыг хөгжүүлэх, анги ахих тутам анхаарлын төвлөрөл суларч байгаа тул хүүхдүүдийг сууж сургах, тодорхой зүйлс анхаарал төвлөрүүлэх дасгал ажиллуулах,
 - **Суурь боловсролын түвшинд** мэдээллийг харж тогтоох чадвар болон анхаарлаа төвлөрүүлэх чадварыг хөгжүүлэх,
 - **Бүрэн дунд боловсролын түвшинд** мэдээллийг утгачлан тогтоох чадвар болон сэтгэхүйн харьцуулах үйлдлийг нь хөгжүүлэх
- Хүүхдүүдийн үгийн нөөцийн хөгжил, ялангуяа хийсвэр, салаа утгатай үг, юмсын шинж чанарыг заасан тэмдэг нэрийн утгын төлөвшил, хэрэглээг нь хөгжүүлэх хэрэгтэй.



Багшийн хувьд:

- Хүүхдүүд цөөн тооны үг, өгүүлбэрээр санаагаа товчхон илэрхийлж байнга тул санаагаа дэлгэрэнгүй, тодорхой, учир шалтгаан холбоо хамааралд нь илэрхийлэх чадварыг сайжруулах.
- Багшийн сурагчдадаа хандах хандлага нь ёс суртахууны, төлөвшил, хэм хэмжээг дагах чадварт нь нөлөөлдөг тул сөрөг харьцаа хандлагаас зайлсхийх.
- Мэдэхгүй зүйлээ багшаасаа асуух нөхцлийг бүрдүүлэх.



Гэр бүл, эцэг эхийн хувьд:

- Гэр бүлийн орчинд хүмүүжих нь тэдний сэтгэлийн хөдөлгөөн, өөртөө итгэх итгэлд эерэгээр нөлөөлдөг тул гэр бүл, ойр дотны хүмүүс хүүхдүүдтэйгээ нээлттэй, идэвхтэй харилцах,
- Хүүхдийг эрт унтуулах,
- Гэр бүлд таатай, дотно уур амьсгал бүрдүүлэх,
- Хүүхдийг аль болох багаас нь тодорхой зүйлд төвлөрч, гүйцэтгүүлж сургах,
- Сургуулиас зохион байгуулж буй ажлуудад оролцоход нь хүүхдээ дэмжих,
- Спортын дугуйлан, секцэд хүүхдээ хамруулах,
- Үе тэнгийнхэн, найз нөхөдтэйгээ харилцах харилцааг нь дэмжих.
- Хүүхэд санаагаа бүтэн өгүүлбэрээр, гүйцэд илэрхийлэх чадварыг нь дэмжих,
- Хүүхдийг тэсвэр тэвчээртэй занд сургах.



БАЯРЛАЛАА

